

Монгол Улсын Сонгуулийн ерөнхий хорооны
2020 оны ... дугаар сарын ...-ны өдрийн
... дугаар тогтоолын хавсралт

СОНГУУЛИЙН БАРИМТ БИЧГИЙГ БҮРТГЭХ, ЭМХЛЭН ЦЭГЦЛЭХ, ХҮЛЭЭЛЦЭХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Сонгуулийн үйл ажиллагааны явцад хамаарах баримт бичгийг /цаашид “баримт бичиг” гэх/ бүртгэх, эмхлэн цэгцлэх, хүлээлцэх ажиллагааг зохицуулахад энэхүү журмын зорилго оршино.

1.2. Сонгуулийн байгууллагууд энэ журмын 2.1-д заасан нийтлэг баримт бичгүүдээс гадна тус тусын чиг үүрэгт хамаарах баримт бичгийг бүртгэн цэгцэлж, санал хураалт дууссаны дараа энэ журамд заасан хугацаанд хэсгийн хороо нь сум, дүүргийн сонгуулийн хороонд, сум, дүүргийн сонгуулийн хороо нь аймаг, нийслэлийн сонгуулийн хороонд, аймаг, нийслэлийн сонгуулийн хороо нь Монгол Улсын Сонгуулийн ерөнхий хороонд тус тус хүлээлгэн өгнө.

Хоёр. Сонгуулийн үйл ажиллагааны явцад үүсэх нийтлэг баримт бичиг

- 2.1. Сонгуулийн үйл ажиллагааны явцад дараах баримт бичиг үүснэ. Үүнд:
- 2.1.1. Сонгуулийн хорооны тогтоол;
 - 2.1.2. Сонгуулийн хорооны даргын захирамж;
 - 2.1.3. Сонгуулийн хорооны хуралдааны тэмдэглэл;
 - 2.1.4. Сонгуулийн хорооны төлөвлөгөө, тайлан;
 - 2.1.5. Харилцсан бичиг;
 - 2.1.6. Өргөдөл, гомдол шийдвэрлэсэн талаарх мэдээ, тайлан;
 - 2.1.7. Сонгуулийн төсвийн хуваарилалт, зардлын тайлан, холбогдох баримт;
 - 2.1.8. Нам, эвслийн сонгууль эрхэлсэн байгууллагын ажилтан, нэр дэвшигчийн менежер, шадар туслагч, ухуулагчийн бүртгэл;
 - 2.1.9. Саналын хуудас хүлээлцсэн тэмдэглэл, зарцуулалтын тайлан, мэдээ;
 - 2.1.10. Ирцийн мэдээ болон санал өгсөн сонгогчдын нас, хүйсийн судалгаа;
 - 2.1.11. Санал тоолох төхөөрөмжийн иж бүрдлийг хүлээлцсэн баримт;
 - 2.1.12. Санал тоолох төхөөрөмжөөс хэвлэгдсэн санал хураалтын дүнгийн хуудас;
 - 2.1.13. Сонгогчдын санал авахад хэрэглэсэн битүүмжилсэн хүчинтэй болон хүчингүй саналын хуудас;

Гурав. Сонгуулийн баримт бичгийг бүртгэх

- 3.1. Аймаг, нийслэлийн сонгуулийн хороо дараах баримт бичгийг бүртгэнэ. Үүнд:
- 3.1.1. Сонгуулийн хорооны тогтоол;
 - 3.1.2. Сонгуулийн хорооны даргын захирамж;
 - 3.1.3. Сонгуулийн хорооны хуралдааны тэмдэглэл;
 - 3.1.4. Харилцсан бичиг.
- 3.2. Сум, дүүргийн сонгуулийн хороо дараах баримт бичгийг бүртгэнэ. Үүнд:
- 3.2.1. Сонгуулийн хорооны тогтоол;
 - 3.2.2. Сонгуулийн хорооны даргын захирамж;
 - 3.2.3. Сонгуулийн хорооны хуралдааны тэмдэглэл;
 - 3.2.4. Харилцсан бичиг.

3.3.Хэсгийн хороо дараах баримт бичгийг бүртгэнэ. Үүнд:

3.3.1.Харилцсан бичиг.

3.4.Сонгуулийн баримт бичгийг цаг хугацааны дараалал, төрөл тус бүрээр ангилан төрийн албан хэрэг хөтлөлтийн үндсэн зааврын дагуу хөтлөж, тусгай дэвтэрт бүртгэнэ.

3.5.Сонгуулийн баримт бичгийг холбогдох этгээд бүртгэхдээ тухайн баримт бичгийн огноо, дугаар, гарын үсэг, тэмдэг гэх мэт бүрдлүүд бүрэн эсэхийг нягтална.

3.6.Сонгуулийн баримт бичгийн бүртгэлийн дэс дугаар, огноо, доторх агуулгыг өөрчлөх, солих, засвар оруулах, бичигдсэн зүйлийг дарахыг хориглоно.

Дөрөв. Сонгуулийн баримт бичгийг эмхлэн цэгцлэх, хүлээлцэх

4.1.Сонгуулийн хороод нь үйл ажиллагааны явцад үүсгэж хөтөлсөн баримт бичгээ эмхлэн цэгцлэхдээ дараах зүйлсийг анхаарч ажиллана. Үүнд:

4.1.1.Баримтыг үдэж хавтаслахдаа урд талд нь “Ашиглалтын хуудас”, “Дотоод товъёог”, хойд талд нь “Баталгааны хуудас”-ыг заавал үднэ.

4.1.2.Үдэж хавтасласан хадгаламжийн нэгжид “Нүүр бичилт”-ийг хар өнгийн үзэг /бал/-ээр бичнэ. /фломастер болон маркераар бичихийг хориглоно./

4.1.3.Нүүр бичилтэд буй Х№, Д№, ХН№ зэрэг мэдээлэл бүхий “Архивын шифр”-ийн Х№, Д№-ыг бичихгүй бөгөөд ХН№-т тухайн баримтын бүртгэлийн дугаарыг харандаагаар бичиж түр дугаар олгоно.

4.1.4.Хадгаламжийн нэгжийн нүүр бичилтэд “Эхэлсэн, дууссан огноо” тэмдэглэгээг хийхдээ тухайн хадгаламжийн нэгжид буй эхний баримтын огноо нь “Эхэлсэн огноо”, сүүлийн баримтын огноо нь “Дууссан огноо” болно.

4.1.5.“Хадгалах хугацааны жагсаалтын зүйлийн дугаар” хэсэгт тухайн баримт бичгийн хадгалах хугацааг тогтоосон жагсаалтын зүйлийн дугаарыг бичнэ. Тухайлбал, ҮЖ-12, БЖ-56 гэх мэт.

4.1.6.“Хадгалах хугацаа” хэсэгт “Байнга”, “15 жил НШ” гэх зэрэг хадгалах хугацааны заалтыг бичнэ.

4.2.Хэсгийн хороо нь энэ журмын 2.1-т заасан баримт бичгийг сонгууль дууссанаас хойш 3 хоногийн дотор сум, дүүргийн сонгуулийн хороонд, сум, дүүргийн сонгуулийн хороо нь 5 хоногийн дотор аймаг, нийслэлийн сонгуулийн хороонд тус тус хүргүүлнэ.

4.3.Аймаг, нийслэлийн сонгуулийн хороо нь доор дурдсан баримт бичгийг эмхлэн цэгцэлж, үдэж хавтаслан сонгууль дууссанаас хойш 14 хоногийн дотор Сонгуулийн ерөнхий хороонд хүлээлгэн өгнө. Үүнд:

4.3.1.Нэгдсэн дүн;

4.3.2.Сонгуулийн дүнгийн тухай хуралдааны тэмдэглэл;

4.3.3.Хэсэг дэх санал тоолох төхөөрөмжөөс хэвлэгдсэн санал хураалтын дүнгийн хуудас;

4.3.4.Саналын хуудасны зарцуулалтын тайлан;

4.3.5.Ажлын тайлан;

4.3.6.Сонгуулийн зардлын тайлан.

4.4.Аймаг, нийслэлийн сонгуулийн хороо энэ журмын 4.3-т зааснаас бусад баримт бичгийг аймаг, нийслэлийн архивт хүлээлгэн өгнө. Ингэхдээ энэ журмын 2 дугаар зүйлийн 2.1.13-т заасан баримтын битүүмжилсэн баглаа боодлыг нь задлахыг хориглоно.

4.5.Бүх шатны сонгуулийн хороод нь сонгуулийн баримт бичгийг шилжүүлэн өгөхдөө баримт хүлээлцсэн акт үйлдэнэ. Архивт шилжүүлэхдээ уг ажиллагаанд байлцсан гишүүд, архивын эрхлэгч тус тус гарын үсэг зурж зохих журмын дагуу хадгална.

Тав. Хүлээх хариуцлага

5.1. Сонгуулийн тухай хууль тогтоомж болон энэ журамд заасныг зөрчсөн этгээдэд холбогдох хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

5.2. Сонгуулийн хороод нь Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль болон энэ журамд заасныг зөрчсөн эсэхийг холбогдох байгууллагад шалгуулахаар хүргүүлнэ.

---oOo---